

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Түргэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/17/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаангом хот
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг:
BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgаланm@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Батсайхан

Утас: 70453799, Цахим хаяг: BatsaikhanS@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	15
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлтүүд.....	15
4. Аудитын тайлан.....	20
4.1 Ерөнхий зүйл	20
4.2 Материаллаг байдал	20
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	21
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	21
5. Аудитын илрүүлэлт	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

ТҮРГЭН СУМЫН ЗАСАГ ДАРГА
Л.БУЯНЖАРГАЛ ТАНАА

2023.03.21 № УБХ-2023/17/НА-СГА-ТТЗ
танай -ны № -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Түргэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Түргэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант хугацаанд сумын орон нутгийн орлогын төлөвлөгөө 124 хувийн биелэлттэй байхад аймгийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/697 дугаар захирамжийн дагуу сумын орон нутгийн орлогоос 30.0 сая төгрөгийг аймгийн орон нутгийн орлогод татаж авсан байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

0200700211

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A red square official stamp of the State Audit Agency of Mongolia is placed over a handwritten signature in black ink. The signature is written in a cursive style and appears to be 'М.Батсуурь'. The stamp contains Mongolian text and a central emblem.

М.БАТСУУРЬ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	869,879,019.21	536,933,730.25
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	290,701,167.07	265,290,811.05
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	290,701,167.07	265,290,811.05
31210	Төгрөг	290,701,167.07	265,290,811.05
31211	Төрийн сангийн харилцах	290,701,167.07	265,290,811.05
33	АВЛАГА	266,876,120.00	175,548,871.76
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	126,591,100.00	0.00
33400	Зээлийн хүүгийн авлага	3,149,925.00	9,728,836.00
33500	Бусад авлага	38,963,170.00	34,008,810.76
33510	Байгууллагаас авах авлага	15,577,000.00	10,657,580.76
33520	Хувь хүмүүсээс авах авлага	23,386,170.00	23,351,230.00
33600	Зээлийн авлага	98,171,925.00	131,811,225.00
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	98,171,925.00	131,811,225.00
33612	Хувь хүмүүст олгосон зээл	98,171,925.00	131,811,225.00
35	БАРАА МАТЕРИАЛ	312,301,732.14	96,094,047.44
35100	Түүхий эд материал	13,021,450.00	0.00
35130	Эм боох материал	13,021,450.00	0.00
35400	Хангамжийн материал	298,380,282.14	88,099,381.44
35410	Бичиг хэргийн материал	7,999,386.28	2,137,690.00
35420	Аж ахуйн материал	273,555,103.86	79,126,691.44
35430	Сэлбэг хэрэгсэл	7,167,000.00	6,835,000.00
35440	Түлш, шатах тослох материал	6,655,150.00	0.00
35460	Хүнсний материал	3,003,642.00	0.00
35600	Мал амьтад	900,000.00	7,994,666.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,413,546,544.19	2,139,402,408.82
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,413,546,544.19	2,139,402,408.82
39200	Биет хөрөнгө	8,210,244,969.19	1,505,629,583.82
39201	Барилга, байгууламж, орон сууц	8,129,683,499.01	1,565,383,649.61
39202	Хуримтлагдсан элэгдэл	-717,018,963.93	-474,075,439.92
39203	Авто-тээврийн хэрэгсэл	398,926,895.00	329,941,303.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-184,231,348.00	-142,545,692.65
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	651,240,992.71	268,686,476.84
39206	Хуримтлагдсан элэгдэл	-403,590,217.02	-167,731,073.92
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	290,195,501.57	52,632,956.97
39208	Хуримтлагдсан элэгдэл	-130,514,368.58	-28,026,272.94
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	30,687,750.00	0.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	159,993,724.00	167,397,182.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-55,587,392.27	-66,033,505.17
39217	Ном	40,458,896.70	0.00
39300	Биет бус хөрөнгө	203,301,575.00	633,772,825.00
39301	Програм хангамж	5,505,000.00	3,125,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-4,250,625.00	-2,749,375.00
39303	Бусад биет бус хөрөнгө	202,047,200.00	633,397,200.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	9,283,425,563.40	2,676,336,139.07
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	26,777,350.15	14,682,177.62
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	26,777,350.15	14,682,177.62
41300	Өглөг	26,777,350.15	14,682,177.62
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	94,534.15	3,710,647.62
41360	Бусад өглөг	26,682,816.00	10,971,530.00

41361	Байгууллагад төлөх өглөг	23,528,816.00	846,530.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	3,154,000.00	10,125,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,256,648,213.25	2,661,653,961.45
51	Засгийн газрын хувь оролцоо	9,256,648,213.25	2,661,653,961.45
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,389,593,867.27	979,425,897.77
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	2,389,593,867.27	979,425,897.77
51200	Хуримтлагдсан үр дүн	5,802,163,526.00	1,351,095,741.74
51210	Өмнөх үеийн үр дүн	4,054,059,424.06	8,281,812,800.09
51220	Тайлант үеийн үр дүн	1,748,104,101.94	-6,930,717,058.35
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,064,890,819.98	331,132,321.94
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	9,283,425,563.40	2,676,336,139.07

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,506,958,315.18	1,282,126,707.17
11	ТАТВАРЫН ОРЛОГО	63,986,223.89	197,884,940.17
110	Орлогын албан татвар	28,969,806.89	114,763,130.61
1100	Хувь хүний орлогын албан татвар	28,969,806.89	114,763,130.61
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	0.00	78,936,453.40
110002	Үйл ажиллагааны орлого	8,747,760.10	13,302,558.13
110003	Хөрөнгийн орлого	16,407,217.79	11,211,262.08
110004	Хөрөнгө борлуулсны орлого	1,005,050.00	3,158,000.00
110008	Шууд бус орлого	2,809,779.00	8,154,857.00
113	Хөрөнгийн албан татвар	6,176,850.00	19,195,912.56
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	0.00	1,876,862.56
113002	Бууны албан татвар	870,000.00	1,860,000.00
113004	Малд ногдуулах албан татвар	5,306,850.00	15,459,050.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	28,839,567.00	63,925,897.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	8,844,450.00	2,523,404.00
118001	Улсын тэмдэгтийн хураамж	1,136,450.00	508,402.00
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	7,038,000.00	1,325,002.00
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	670,000.00	690,000.00
1181	Газрын төлбөр	17,378,143.00	53,127,657.00
118101	Газрын төлбөр	17,378,143.00	53,127,657.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	2,616,974.00	8,274,836.00
118201	Ойн нөөц ашигласны төлбөр	2,529,474.00	7,666,836.00
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	87,500.00	608,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,015,283,897.36	204,928,967.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,015,283,897.36	204,928,967.00
120003	Торгуулийн орлого	20,653,300.00	30,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,994,233,597.36	202,998,967.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,570,879.00	10,875,343.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,974,512,793.36	188,474,372.00
1200046	Зээлийн хүүгийн орлого	3,149,925.00	3,649,252.00
120009	Бусад орлого	397,000.00	1,900,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,427,688,193.93	879,312,800.00

1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,304,611,964.00	90,546,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,233,325,100.00	0.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	71,286,864.00	90,546,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	377,518,385.00	117,243,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	11,000,000.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,250,000.00	1,840,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	355,268,385.00	115,403,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,655,568,800.00	661,398,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	855,884,400.00	0.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	799,684,400.00	661,398,800.00
1330	Төсвийн захирагчдаас	68,548,944.93	10,125,000.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	68,548,944.93	10,125,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	21,440,100.00	0.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	21,440,100.00	0.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,590,959,565.56	1,168,505,898.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,590,959,565.56	1,168,505,898.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,546,775,602.66	1,152,824,914.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,383,418,738.20	415,818,272.65
210101	Үндсэн цалин	1,102,850,929.20	300,592,945.75
210102	Нэмэгдэл	126,195,612.00	57,414,718.25
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,091,000.00	0.00
210104	Урамшуулал	89,365,977.00	33,482,853.80
210105	Гэрээт ажлын хөлс	60,915,220.00	24,327,754.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	180,602,375.08	51,209,829.24
210201	Тэтгэврийн даатгал	128,369,914.41	35,434,398.81
210202	Тэтгэмжийн даатгал	13,573,307.95	4,176,963.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,665,116.23	3,341,570.40
210204	Ажилгүйдлийн даатгал	2,603,277.12	741,685.94
210205	Эрүүл мэндийн даатгал	25,390,759.37	7,515,211.07
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	271,321,416.37	273,768,820.56
210301	Гэрэл, цахилгаан	10,241,285.37	12,299,514.56
210302	Түлш, халаалт	257,596,881.00	260,916,306.00
210303	Цэвэр, бохир ус	1,405,330.00	403,000.00
210304	Байрны түрээс	2,077,920.00	150,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	92,005,614.00	125,922,592.80
210401	Бичиг хэрэг	15,248,965.00	4,445,600.00
210402	Тээвэр, шатахуун	42,567,030.00	45,982,050.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,600,100.00	2,181,494.00
210404	Ном, хэвлэл	192,000.00	96,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,109,350.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,486,159.00	72,701,700.00
210408	Бараа материал акталсны зардал	18,802,010.00	515,748.80
2105	Нормативт зардал	166,072,944.85	0.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	131,096,453.00	0.00

210502	Хоол, хүнс	34,976,491.85	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	50,023,608.00	7,924,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	38,603,508.00	0.00
210604	Урсгал засвар	11,420,100.00	7,924,600.00
2107	Томилолт, зочны зардал	7,166,500.00	6,920,000.00
210702	Дотоод албан томилолт	7,166,500.00	6,920,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,710,873.00	28,841,953.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,173,200.00	26,789,113.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,735,200.00	540,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	308,740.00	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	245,213.00	70,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.00	165,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,742,500.00	644,500.00
210807	Газрын төлбөр	374,020.00	433,340.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	388,453,533.16	242,418,845.81
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,782,115.00	66,638,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,501,500.00	14,426,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	349,169,918.16	161,354,845.81
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,044,183,962.90	15,680,984.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	90,752,300.00	15,680,984.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,085,900.00	12,552,984.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38,914,000.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	33,752,400.00	3,128,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	924,433,344.93	0.00
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	855,884,400.00	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	61,477,644.93	0.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	7,071,300.00	0.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	28,998,317.97	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,998,317.97	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,915,998,749.62	113,620,809.11
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	167,894,647.68	7,044,337,867.46
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	99,174,523.68	0.00
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	68,720,124.00	6,782,978,065.56
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	0.00	261,359,801.90
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,748,104,101.94	-6,930,717,058.35

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,491,634,541.82	1,147,982,124.17
11	ТАТВАРЫН ОРЛОГО	63,986,223.89	197,884,940.17
110	Орлогын албан татвар	28,969,806.89	114,763,130.61
1100	Хувь хүний орлогын албан татвар	28,969,806.89	114,763,130.61
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	0.00	78,936,453.40
110002	Үйл ажиллагааны орлого	8,747,760.10	13,302,558.13
110003	Хөрөнгийн орлого	16,407,217.79	11,211,262.08
110004	Хөрөнгө борлуулсны орлого	1,005,050.00	3,158,000.00
110008	Шууд бус орлого	2,809,779.00	8,154,857.00
113	Хөрөнгийн албан татвар	6,176,850.00	19,195,912.56
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	0.00	1,876,862.56
113002	Бууны албан татвар	870,000.00	1,860,000.00
113004	Малд ногдуулах албан татвар	5,306,850.00	15,459,050.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	28,839,567.00	63,925,897.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	8,844,450.00	2,523,404.00
118001	Улсын тэмдэгтийн хураамж	1,136,450.00	508,402.00
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	7,038,000.00	1,325,002.00
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	670,000.00	690,000.00
1181	Газрын төлбөр	17,378,143.00	53,127,657.00
118101	Газрын төлбөр	17,378,143.00	53,127,657.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	2,616,974.00	8,274,836.00
118201	Ойн нөөц ашигласны төлбөр	2,529,474.00	7,666,836.00
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	87,500.00	608,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	126,551,224.00	70,784,384.00
120	Нийтлэг татварын бус орлого	126,551,224.00	70,784,384.00
120003	Торгуулийн орлого	20,653,300.00	30,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	103,923,924.00	60,306,384.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	103,923,924.00	60,306,384.00
120009	Бусад орлого	1,974,000.00	10,448,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,301,097,093.93	879,312,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,304,611,964.00	90,546,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,233,325,100.00	0.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	71,286,864.00	90,546,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	250,927,285.00	117,243,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	11,000,000.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,250,000.00	1,840,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	228,677,285.00	115,403,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,655,568,800.00	661,398,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	855,884,400.00	0.00

132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	799,684,400.00	661,398,800.00
1330	Төсвийн захирагчдаас	68,548,944.93	10,125,000.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	68,548,944.93	10,125,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	21,440,100.00	0.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	21,440,100.00	0.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,222,592,268.40	1,026,929,710.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,222,592,268.40	1,026,929,710.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,178,408,305.50	999,779,752.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,383,283,879.20	412,940,205.79
210101	Үндсэн цалин	1,103,450,036.20	297,414,878.89
210102	Нэмэгдэл	126,195,612.00	57,414,718.25
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,934,000.00	0.00
210104	Урамшуулал	88,787,077.00	33,782,853.80
210105	Гэрээт ажлын хөлс	60,917,154.00	24,327,754.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	180,642,699.93	51,209,829.24
210201	Тэтгэврийн даатгал	128,410,239.26	35,434,398.81
210202	Тэтгэмжийн даатгал	13,573,307.95	4,176,963.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,665,116.23	3,341,570.40
210204	Ажилгүйдлийн даатгал	2,603,277.12	741,685.94
210205	Эрүүл мэндийн даатгал	25,390,759.37	7,515,211.07
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	272,728,968.37	273,768,820.56
210301	Гэрэл, цахилгаан	10,051,637.37	12,299,514.56
210302	Түлш, халаалт	258,878,881.00	260,916,306.00
210303	Цэвэр, бохир ус	1,720,530.00	403,000.00
210304	Байрны түрээс	2,077,920.00	150,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	83,766,970.00	131,340,344.00
210401	Бичиг хэрэг	6,405,238.00	3,944,100.00
210402	Тээвэр, шатахуун	39,081,380.00	45,982,050.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,612,600.00	2,481,494.00
210404	Ном, хэвлэл	204,400.00	96,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,978,102.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	27,485,250.00	78,836,700.00
2105	Нормативт зардал	154,798,694.00	0.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	113,294,894.00	0.00
210502	Хоол, хүнс	33,872,800.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,631,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43,367,306.00	13,884,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	616,200.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	32,260,706.00	0.00
210604	Урсгал засвар	10,490,400.00	13,884,600.00
2107	Томилолт, зочны зардал	7,166,500.00	6,920,000.00
210702	Дотоод албан томилолт	7,166,500.00	6,920,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,811,873.00	29,291,953.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,274,200.00	27,239,113.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,735,200.00	540,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	308,740.00	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	245,213.00	70,000.00

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.00	165,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,742,500.00	644,500.00
210807	Газрын төлбөр	374,020.00	433,340.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,841,415.00	80,424,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,597,415.00	65,998,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,244,000.00	14,426,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,044,183,962.90	27,149,957.60
2132	Бусад урсгал шилжүүлэг	90,752,300.00	15,680,984.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,085,900.00	12,552,984.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38,914,000.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	33,752,400.00	3,128,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	924,433,344.93	10,125,000.00
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	855,884,400.00	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	61,477,644.93	0.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	7,071,300.00	10,125,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	28,998,317.97	1,343,973.60
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,998,317.97	0.00
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	0.00	1,343,973.60
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	269,042,273.42	121,052,413.98
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	92,383,224.00	60,462,770.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	92,383,224.00	60,462,770.00
2200	Дотоод эх үүсвэрээр	92,383,224.00	60,462,770.00
223001	Бусад хөрөнгө	70,720,124.00	26,636,470.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	21,663,100.00	33,826,300.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-92,383,224.00	-60,462,770.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-30,000,000.00	-86,000,000.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	30,000,000.00	86,000,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	30,000,000.00	86,000,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	146,659,049.42	-25,410,356.02
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	144,042,117.65	290,701,167.07
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	290,701,167.07	265,290,811.05

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,389,593,867.27	1,126,278,911.98	3,992,671,332.06	7,508,544,111.31
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	61,388,092.00	61,388,092.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,389,593,867.27	1,126,278,911.98	4,054,059,424.06	7,569,932,203.31
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-61,388,092.00	0.00	-61,388,092.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,748,104,101.94	1,748,104,101.94
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,389,593,867.27	1,064,890,819.98	5,802,163,526.00	9,256,648,213.25
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,389,593,867.27	1,064,890,819.98	5,802,163,526.00	9,256,648,213.25
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,865,083,969.50	-733,758,498.04	3,843,119,215.92	6,441,961,683.46
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	524,509,897.77	331,132,321.94	1,959,044,310.08	2,814,686,529.79
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	454,916,000.00	0.00	0.00	454,916,000.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	6,930,717,058.35	6,930,717,058.35
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	979,425,897.77	331,132,321.94	1,351,095,741.74	2,661,653,961.45

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/ төгрөгөөр / Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,201,702,500.00	1,044,680,506.59	250,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	973,791,300.00	932,044,036.59	250,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	958,105,300.00	916,363,052.59	250,000.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	419,275,100.00	412,940,205.79	0.00
210101	Үндсэн цалин	388,475,100.00	297,414,878.89	0.00
210102	Нэмэгдэл	0.00	57,414,718.25	0.00
210104	Урамшуулал	6,000,000.00	33,782,853.80	0.00
210105	Гэрээт ажлын хөлс	24,800,000.00	24,327,754.85	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,538,000.00	51,209,829.24	0.00
210201	Тэтгэврийн даатгал	36,511,900.00	35,434,398.81	0.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,006,600.00	4,176,963.02	0.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,205,300.00	3,341,570.40	0.00
210204	Ажилгүйдлийн даатгал	801,000.00	741,685.94	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,013,200.00	7,515,211.07	0.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	297,908,600.00	273,768,820.56	0.00
210301	Гэрэл, цахилгаан	19,572,400.00	12,299,514.56	0.00
210302	Түлш, халаалт	272,062,800.00	260,916,306.00	0.00
210303	Цэвэр, бохир ус	4,099,000.00	403,000.00	0.00
210304	Байрны түрээс	2,174,400.00	150,000.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	53,453,700.00	52,747,344.00	0.00
210401	Бичиг хэрэг	4,123,600.00	3,944,100.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	34,431,300.00	34,519,550.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,494,000.00	2,481,494.00	0.00
210404	Ном, хэвлэл	192,000.00	96,000.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	482,000.00	0.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,730,800.00	11,706,200.00	0.00
2105	Нормативт зардал	2,456,300.00	0.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,456,300.00	0.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	46,835,300.00	46,010,900.00	0.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	32,200,000.00	32,126,300.00	0.00
210604	Урсгал засвар	14,635,300.00	13,884,600.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	7,458,300.00	6,920,000.00	0.00
210702	Дотоод албан томилолт	7,458,300.00	6,920,000.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,294,500.00	2,966,953.00	0.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,600,000.00	914,113.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	540,000.00	0.00

210803	Даатгалын үйлчилгээ	375,000.00	200,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	285,000.00	70,000.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	198,000.00	165,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	839,700.00	644,500.00	0.00
210807	Газрын төлбөр	456,800.00	433,340.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	69,885,500.00	69,799,000.00	250,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	55,436,000.00	55,373,000.00	250,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,449,500.00	14,426,000.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,686,000.00	15,680,984.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,686,000.00	15,680,984.00	0.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,553,000.00	12,552,984.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,133,000.00	3,128,000.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	137,911,200.00	26,636,470.00	0.00
223001	Бусад хөрөнгө	137,911,200.00	26,636,470.00	0.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	90,000,000.00	86,000,000.00	0.00
230001	Эргэж төлөгдөх зээл	90,000,000.00	86,000,000.00	0.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,201,702,500.00	1,082,281,738.59	5,018,460.16
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	90,546,000.00	90,546,000.00	-
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	90,546,000.00	90,546,000.00	0.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,000,138,800.00	931,429,354.59	931,447,814.75
320001	Орон нутгийн төсвөөс	1,000,138,800.00	931,429,354.59	931,447,814.75
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	111,017,700.00	60,306,384.00	0.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	23,652,500.00	60,306,384.00	0.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	87,365,200.00	0.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	111,507,708.40	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	147,764,966.80	1,343,973.60

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	/ төгрөгөөр / ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	117,243,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	117,243,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	107,118,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	79,493,000.00
210402	Тээвэр, шатахуун	11,462,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	68,030,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,325,000.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,325,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,300,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,300,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,125,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,125,000.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	10,125,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	117,243,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	117,243,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,840,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	115,403,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Түргэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай, чанартай, хүртээмжтэй хүргэх гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Түргэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Түргэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 265.3 сая төгрөг болж, өмнөх оноос 25.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт (+), Бууралт (-)</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
Төрийн сангийн харилцах	290.7	265.3	-25.4	100
Дүн	290.7	265.3	-25.4	100

Эх сурвалж: Түргэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэлд сумын орон нутгийн ерөнхий орлогын 117.5 сая, орон нутгийн хөгжлийн сангийн 90.2 сая, Хоршоо хөгжүүлэх сангийн 57.5 сая төгрөг тус тус байршиж байна.

3.5.2 Авлага

Авлага дансны үлдэгдэл 175.5 сая төгрөг болж, 91.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төлбөртэй үйлчилгээний авлага	126.6	0.0	-126.6
Зээлийн хүүгийн авлага	3.1	9.7	6.6
Байгууллагаас авах авлага	15.6	10.6	-5.0
Хувь хүмүүсээс авах авлага	23.4	23.4	0.0
Зээлийн авлага	98.2	131.8	33.6
Дүн	266.9	175.5	-91.4

Эх сурвалж: Түргэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэлд Орон нутгийн хөгжлийн сангийн 3.1 сая, Хоршоо хөгжүүлэх сангийн 160.1 сая, ойн ангийн 10.6 сая, Засаг даргын тамгын газрын 0.8 сая төгрөгийн авлагууд тус тус байршиж байна.

3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 312.4 сая, эцсийн үлдэгдэл 96.0 сая төгрөг болж, 216.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	0.0	0.0	0.0
Эм боох материал	13.0	0.0	-13.0
Бичиг хэргийн материал	8.0	2.1	-5.9
Аж ахуйн материал	273.6	79.1	-194.5
Сэлбэг хэрэгсэл	7.2	6.8	-0.4
Түлш шатах тослох материал	6.7	0.0	-6.7
Хүнсний материал	3.0	0.0	-3.0
Бусад хангамжийн материал	0.0	0.0	0.0
Мал амьтад	0.9	8.0	7.1
Дүн	312.4	96.0	-216.4

Эх сурвалж: Түргэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэлд Орон нутгийн хөгжлийн сангийн 11.6 сая, ойн ангийн 11.1 сая, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 1.5 сая, Засаг даргын тамгын газрын 71.8 сая төгрөгийн бараа материал тус тус байршиж байна.

Бараа материал дансны үлдэгдэл 216.4 сая төгрөгөөр буурсан нь тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын бараа материалыг улсын төсвийн дансанд шилжүүлсэнтэй холбоотой байна.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 8,413.3 сая, эцсийн үлдэгдэл 2,139.5 сая төгрөг болж, 6,273.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	8,129.6	1,565.4	6,564.2
Хуримтлагдсан элэгдэл	-717.0	-474.1	-242.9
Авто тээврийн хэрэгсэл	398.9	329.9	-69.0
Хуримтлагдсан элэгдэл	-184.2	-142.5	-41.7
Машин тоног төхөөрөмж (компьютер)	651.2	268.7	-382.5
Хуримтлагдсан элэгдэл	-403.6	-167.7	-235.9
Тавилга, аж ахуйн эд хогшил	290.2	52.6	-237.6
Хуримтлагдсан элэгдэл	-130.5	-28.0	-102.5
Зам гүүрний барилга байгууламж	0.0	0.0	0.0
Хуримтлагдсан элэгдэл	0.0	0.0	0.0

Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	30.7	0.0	0.0
Бусад үндсэн хөрөнгө	159.9	167.4	7.5
Хуримтлагдсан элэгдэл	-55.6	-66.0	10.4
Ном	40.4	0.0	-40.4
Программ хангамж	5.5	3.1	-2.4
Хуримтлагдсан элэгдэл	-4.2	-2.7	-1.5
Бусад биет бус хөрөнгө	202.0	633.4	431.4
Дүн	8,413.3	2,139.5	-6,273.8

Эх сурвалж: Түргэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,139.5 сая төгрөг болж 6,273.8 сая төгрөгөөр буурсан нь тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын үндсэн хөрөнгийг улсын төсвийн дансанд шилжүүлсэнтэй холбоотой байна.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 26.7 сая, эцсийн үлдэгдэл 14.6 сая төгрөг болж, 12.1 төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Ажилчидтай холбоотой өглөг	0.09	3.7	3.6
Байгууллагад төлөх өглөг	23.5	0.8	-22.7
Хувь хүмүүст төлөх өглөг	3.1	10.1	7.0
Нийт дүн	26.7	14.6	-12.1

Эх сурвалж: Түргэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдэл 14.6 сая төгрөг болж 12.1 төгрөгөөр буурсан нь байгууллагад төлөх өглөг буурснаас шалтгаалжээ.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 5,817.9 сая, эцсийн үлдэгдэл 1,785.0 сая төгрөг болж, 4,032.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 6_ Засгийн газрын хувь оролцоо

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+/, бууралт /-/
Засгийн газрын оруулсан капитал			
<u>/Засгийн газрын сан/ орон нутгийн сан</u>	9,256.6	2,661.6	-6595.0
<u>Хуримтлагдсан үр дүн</u>	5,802.2	1,351.1	-4,451.1
<u>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</u>	1,064.9	331.1	-733.8
Дүн	16,123.7	4,343.8	-11,779.9

Эх сурвалж: Түргэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 4,343.8 сая төгрөг болж 11,779.9 сая төгрөгөөр, хуримтлагдсан үр дүн 1,351.1 сая төгрөг болж 4,451.1 сая төгрөгөөр тус тус буурсан нь тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын бараа материалыг улсын төсвийн дансанд шилжүүлсэнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Түргэн сумын 2022 оны төсвийг сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 05/06 дугаар тогтоолоор 1,238.4 сая төгрөгөөр баталж 2022 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн 07/02 дугаар тогтоолоор тодотгол хийж анх баталсан дүнгээс 36.7 сая төгрөгөөр бууруулж 1,201.7 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,201.7 сая төгрөгийн төсөв баталснаас орон нутгийн төсвөөс 1,000.1 сая, урьд оны үлдэгдлээс санхүүжих 87.4 сая, ОНХС-ийн шилжүүлгээр 90.5 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоос 23.6 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 931.4 сая, ОНХС-ийн шилжүүлгээр 90.5 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоос 60.3 сая төгрөгийг санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,044.7 сая төгрөгийг зарцуулж, 37.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,044.7 сая төгрөг буюу 86 хувьтай байгаа нь зардлыг 37.5 сая төгрөгөөр хэмнэж, гүйцэтгэлээр Орон нутгийн татварын орлого 15.7 сая төгрөгөөр давж биелж, 265.3 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарснаас шалтгаалжээ.

Түргэн сумын ИТХ-ын 2022 оны тодотгосон төсөв батлах тухай 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 8/01 дүгээр тогтоолоор Түргэн сумын Засаг дарга тайлант онд 189.6 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 205.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 8.0 хувиар давуулан биелүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 1.8 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 115.6 сая, нийт 117.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж 107.4 сая төгрөгийг зарцуулж 10.1 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Түргэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батсайхан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Түргэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 1/27 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 10.9 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөхгүйгээр нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,187.6 сая төгрөгийн 0.5 хувь буюу 10.9 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 8.7 сая төгрөгөөр тогтоолоо. Материаллаг байдлыг шинж чанарын хувьд авч үзээгүй болно.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Түргэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Тайлант хугацаанд сумын орон нутгийн орлогын төлөвлөгөө 124 хувийн биелэлттэй байхад аймгийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/697 дугаар захирамжийн дагуу сумын орон нутгийн орлогоос 30.0 сая төгрөгийг аймгийн орон нутгийн орлогод татаж авсан байна.

Түргэн сумын 2022 оны татварын орлогын гүйцэтгэл зарим нэр төрлөөр тасарч, зарим нэр төрлөөр давж, нийт дүнгээр 15.7 сая төгрөгөөр давж биелсэн байна. Иймд төсвийн орлогыг бодитой төлөвлөж байхыг зөвлөмж болголоо.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 157 мэдээллээс хугацаандаа оруулсан 146, хугацаа хоцроож 9 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна. Хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Түргэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4.7 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар

Түргэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 6 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 санг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 6 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Дүн										

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 15.7 мянган төгрөгийн 1 зөрчил илэрсэнд зөвлөмж өглөө.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Түргэн сумын 2022 оны татварын орлогын гүйцэтгэл зарим нэр төрлөөр тасарч, зарим нэр төрлөөр давж, нийт дүнгээр 15.7 сая төгрөгөөр давж, 108 хувийн биелэлттэй гарсан байна. Тухайлбал: Хөрөнгийн орлого 4.7 сая, малд ногдуулах албан татвар 14.5 сая, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 8.7 сая, улсын тэмдэгтийн хураамж 0.5 сая төгрөгөөр тус тус тасарч, Цалин хөлс шагнал урамшууллын орлого 9.9 сая, үйл ажиллагааны орлого 10.3 сая, хөрөнгө борлуулсны орлого 1.9 сая, шууд бус орлого 1.1 сая, үл хөдлөх хөрөнгийн татвар 1.1 сая, хог хаягдлын үйлчилгээний хураамж 0.4 сая, ус рашаан ашигласны төлбөр 0.1 сая, татварын бус орлого 7.4 сая, газрын төлбөр 5.1 сая, ойн нөөц ашигласны төлбөр 6.7 сая төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэгт "Сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 66.1.1 дэх заалтад "Тухайн шатны төсвийн төсөл, түүний тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах" Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэгт "Сумын Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 59.1.7 дахь заалтад "хууль тогтоомж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас энэ хуулийн 22.1-д заасан асуудлаар гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах", 59.1.19 дэх хэсэгт "Нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах" гэж заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ сумын татварын орлогыг бодитой төлөвлөөгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сумын татварын орлогыг бодитой төлөвлөж батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Аудитаар алдаа зөрчил илрээгүй.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/сая төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		/сая төгрөгөөр/			
									Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		/сая төгрөгөөр/	
							Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Сумын татварын орлогыг бодитой төлөвлөөгүй байна.	1	15.7					1	15.7
Дүн	1	15.7					1	15.7
Нийт дүн	1	15.7					1	15.7

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /Л.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР  /С.БАТСАЙХАН/

2023 оны 03 сарын 21-ний өдөр